

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр”-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/389/НА-СТА-ТШЗ

|  |   |
|--|---|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: В.Эрдэнэцогт<br>Утас: 261205 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsogtv@audit.gov.mn">erdenetsogtv@audit.gov.mn</a><br>Ахлах аудитор М.Пагамдулам<br>Утас: 261205 Цахим хаяг: <a href="mailto:pagamdulamm@audit.gov.mn">pagamdulamm@audit.gov.mn</a><br>Аудитор: Ж.Бямбацогт<br>Утас: 261205 Цахим хаяг: <a href="mailto:byambatsogtj@audit.gov.mn">byambatsogtj@audit.gov.mn</a> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁРЫН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ А.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

2025.02.25 № 07/660  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр"-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Сургалт эрдэм шинжилгээний танхимын интерьер засварын ажил гүйцэтгэх явцад нэмэлт гэрээ байгуулж, 46,427.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн;
- Түрээслэгч нартай тоног төхөөрөмжийн ашиглалтын гэрээ байгуулаагүй, 4,167.1 мянган төгрөгийн дулааны зардал аваагүй, талбайн хэмжээг дутуу тооцсон;
- Цагийн бүртгэл, илүү цагийн тооцоо зэрэг анхан шатны баримтаар нотлогдоогүй 27,524.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
- Бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн хяналтын тооллого хийхэд 5 нэр төрлийн 1,079.3 мянган төгрөгийн хангамжийн материал зөрүүтэй;
- Ковидын үед бэлтгэсэн 408,735.2 мянган төгрөгийн хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн үлдэгдэлтэй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

20.1.4, заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Бүгд Найрамдах Солонгос Улсын "Хүрээ ротари" клубтэй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хамтын ажиллагааг өргөжүүлсэнээр тус төвийн Нярайн эмгэг судлалын тасагт нэн шаардлагатай 250,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй нийлүүлсэн нь эмчилгээний чанар хүртээмжид эерэгээр нөлөө үзүүлж байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр санхүүжиж байгаагаас жилийн эцэст өр төлбөр 684,368.1 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 567,193.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учирч болзошгүй байна.

### **Бусад асуудал**

Тус төв нь гадаадын улс орны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж Монгол-Швейцарийн хамтарсан хүүхдийн төсөл (SMOPP)-ийн хүрээнд 5 эмч, БНЭУ-ын Альянс Эрүүл Мэндийн Солюшнз компани хүүхдийн зүрхний нээлттэй мэс заслын чиглэлээр 3 эмчийг нарийн мэргэжлийн чиглэлээр сургалтад хамруулсны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрт илрүүлэн таних, эмчлэх нөхцөл бүрдэж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл                             | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|------------|---|--------------------------|--------------------------|
| 1          | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>            | <b>13,182,228,969.14</b> | <b>7,707,712,401.02</b>  |
| 31         | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                     | <b>298,241,188.02</b>    | <b>1,053,626,670.99</b>  |
| 31140      | Касс арилжааны банк                       | 0.00                     | 7,173,000.00             |
| 31211      | Төрийн сангийн харилцах                   | 298,241,188.02           | 1,046,453,670.99         |
| 33         | <b>АВЛАГА</b>                             | <b>6,555,190,253.17</b>  | <b>424,724,649.47</b>    |
| 33200      | Төлбөртэй үйлчилгээний авлага             | 6,286,588,760.00         | 375,015,272.80           |
| 33402      | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/           | 470,323.77               | 5,931,181.18             |
| 335        | Бусад авлага                              | 268,131,169.40           | 43,778,195.49            |
| 3351       | Байгууллагаас авах авлага                 | 267,131,169.40           | 27,542,139.40            |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага                | 1,000,000.00             | 16,236,056.09            |
| 35         | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                     | <b>6,328,797,527.95</b>  | <b>6,229,361,080.56</b>  |
| 35130      | Эм боох материал                          | 4,634,124,738.15         | 4,340,013,756.06         |
| 35410      | Бичиг хэргийн материал                    | 57,511,388.00            | 38,379,630.35            |
| 35420      | Аж ахуйн материал                         | 386,210,014.27           | 277,091,208.73           |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл                           | 59,441,880.01            | 111,730,399.57           |
| 35440      | Түлш, шатах тослох материал               | 28,780,849.04            | 21,950,845.04            |
| 35450      | Барилгын засварын материал                | 21,200,388.66            | 12,904,766.66            |
| 35460      | Хүнсний материал                          | 52,515,993.01            | 35,550,290.79            |
| 35470      | Бусад хангамжийн материал                 | 1,089,012,276.81         | 1,391,740,183.36         |
| 2          | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>        | <b>67,341,774,903.05</b> | <b>62,276,199,757.04</b> |
| 39         | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                     | <b>67,341,774,903.05</b> | <b>62,276,199,757.04</b> |
| 391        | Газар                                     | 0.00                     | 278,800,000.00           |
| 392        | <b>Биет хөрөнгө</b>                       | <b>67,328,479,542.37</b> | <b>61,954,726,208.91</b> |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц            | 29,750,543,141.07        | 29,961,376,029.07        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл                     | (1,699,753,564.35)       | (2,288,843,681.55)       |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл                    | 2,091,500,000.00         | 2,091,500,000.00         |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл                     | (420,217,538.39)         | (769,439,831.21)         |
| 39205      | Машин тоног төхөөрөмж(компьютер)          | 44,512,619,857.32        | 46,860,002,887.32        |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл                     | (12,491,394,645.59)      | (19,059,972,505.88)      |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил               | 3,209,273,718.47         | 3,278,579,718.47         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл                     | (649,501,765.42)         | (973,824,744.09)         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө                      | 3,511,050,456.39         | 3,511,050,456.39         |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл                     | (485,640,117.13)         | (655,702,119.61)         |
| 393        | <b>Биет бус хөрөнгө</b>                   | <b>13,295,360.68</b>     | <b>42,673,548.13</b>     |
| 39301      | Програм хангамж                           | 4,500,293.07             | 36,896,128.56            |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө                    | 8,795,067.61             | 5,777,419.57             |
| 3          | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>        | <b>80,524,003,872.19</b> | <b>69,983,912,158.06</b> |
| 4          | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                     | <b>117,174,095.00</b>    | <b>684,368,063.40</b>    |
| 41         | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>          | <b>117,174,095.00</b>    | <b>684,368,063.40</b>    |
| 413        | <b>Өглөг</b>                              | <b>117,174,095.00</b>    | <b>662,983,363.40</b>    |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг               | 0.00                     | 4,294,707.00             |
| 41361      | Байгууллагад төлөх өглөг                  | 117,174,095.00           | 650,288,656.40           |
| 41362      | Хувь хүмүүст төлөх өглөг                  | 0.00                     | 8,400,000.00             |
| 414        | <b>Урьдчилж орсон орлого</b>              | <b>0.00</b>              | <b>21,384,700.00</b>     |
| 41430      | Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | 0.00                     | 18,160,700.00            |
| 41440      | Бусад урьдчилж орсон орлого               | 0.00                     | 3,224,000.00             |
| 5          | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>           | <b>80,406,829,777.19</b> | <b>69,299,544,094.66</b> |

|       |  |                          |                          |
|-------|--|--------------------------|--------------------------|
| 51    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                     | <b>80,406,829,777.19</b> | <b>69,299,544,094.66</b> |
| 512   | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                            | <b>80,406,829,777.19</b> | <b>69,299,544,094.66</b> |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн                                     | 55,023,544,993.92        | 80,535,293,127.82        |
| 51220 | Тайлант үеийн үр дүн                                   | 25,383,284,783.27        | (11,235,749,033.16)      |
| 6     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН<br/>ДҮН VI=IV+V</b> | <b>80,524,003,872.19</b> | <b>69,983,912,158.06</b> |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**  
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл  | Өмнөх он                 | Тайлант он               |
|------------|--|--------------------------|--------------------------|
| <b>1</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>61,390,190,006.17</b> | <b>26,464,822,372.06</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>42,026,774,866.17</b> | <b>2,622,118,741.06</b>  |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | <b>42,026,774,866.17</b> | <b>2,622,118,741.06</b>  |
| 120004     | Төсөвт байгууллагын өөрийн орлого  | 42,026,774,866.17        | 2,622,118,741.06         |
| 1200041    | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 872,851,273.89           | 773,153,109.00           |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 293,595,511.06           | 453,865,500.18           |
| 1200044    | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө  | 40,327,668,273.30        | 1,109,249,930.00         |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал  | 532,659,807.92           | 285,850,201.88           |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>19,363,415,140.00</b> | <b>23,842,703,631.00</b> |
| 1310       | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | <b>0.00</b>              | <b>570,585,480.00</b>    |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>0.00</b>              | <b>570,585,480.00</b>    |
| 131101     | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 0.00                     | 13,585,480.00            |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00                     | 557,000,000.00           |
| 1340       | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>  | <b>19,363,415,140.00</b> | <b>23,272,118,151.00</b> |
| 134002     | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих  | 19,363,415,140.00        | 23,272,118,151.00        |
| <b>2</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>35,966,056,643.34</b> | <b>37,695,042,773.55</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>35,966,056,643.34</b> | <b>37,695,042,773.55</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>35,831,112,385.54</b> | <b>37,293,510,271.74</b> |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>13,854,961,986.22</b> | <b>16,505,379,522.30</b> |
| 210101     | Үндсэн цалин   | 6,482,269,353.51         | 8,369,944,528.46         |
| 210102     | Нэмэгдэл   | 5,096,172,857.15         | 6,348,741,754.41         |
| 210103     | Унаа хоолны хөнгөлөлт  | 1,010,064,000.00         | 1,056,569,566.62         |
| 210104     | Урамшуулал   | 1,039,148,713.57         | 728,487,320.36           |
| 210105     | Гэрээт ажлын хөлс  | 227,307,061.99           | 1,636,352.45             |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>1,729,388,008.24</b>  | <b>2,062,165,098.64</b>  |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 1,189,076,764.19         | 1,395,824,350.24         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 139,875,207.77           | 164,900,517.97           |
| 210203     | ҮОМШ өвчний даатгал  | 110,914,565.63           | 108,796,403.95           |
| 210204     | Ажилгүйдлын даатгал  | 25,984,273.65            | 81,970,828.53            |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 263,537,197.00           | 310,672,997.95           |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>1,001,510,850.38</b>  | <b>934,051,552.98</b>    |
| 210301     | Гэрэл цахилгаан  | 368,908,328.41           | 500,616,507.95           |
| 210302     | Түлш, халаалт  | 178,664,718.78           | 153,966,906.87           |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 453,937,803.19           | 279,468,138.16           |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>1,018,825,671.29</b>  | <b>719,213,398.58</b>    |
| 210401     | Бичиг хэрэг  | 186,461,335.51           | 151,593,264.32           |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 47,772,519.36            | 44,035,274.00            |
| 210403     | Шуудан холбоо, интернэтийн төлбөр  | 31,736,505.67            | 22,453,886.68            |
| 210404     | Ном, хэвлэл  | 2,049,750.00             | 0.00                     |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 93,687,700.00            | 143,014,300.50           |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 381,671,123.37           | 293,011,397.53           |
| 210408     | Бараа материал акталсны зардал   | 275,446,737.38           | 65,105,275.55            |
| 2105       | <b>Нормативт зардал</b>  | <b>9,763,174,741.71</b>  | <b>8,266,721,251.46</b>  |

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

|        |  |                          |                            |
|--------|--|--------------------------|----------------------------|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 8,252,820,965.00         | 6,726,266,115.12           |
| 210502 | Хоол, Хүнс   | 1,354,511,572.71         | 1,332,282,716.08           |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 155,842,204.00           | 208,172,420.26             |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>227,798,937.90</b>    | <b>340,655,069.03</b>      |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл   | 10,218,000.00            | 5,332,000.00               |
| 210604 | Урсгал засвар  | 217,580,937.90           | 335,323,069.03             |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>18,844,000.00</b>     | <b>53,350,000.00</b>       |
| 210702 | Дотоод албан томилолт  | 18,844,000.00            | 53,350,000.00              |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>351,861,929.46</b>    | <b>360,302,314.74</b>      |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 289,506,080.90           | 291,351,548.00             |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 12,000,000.00            | 0.00                       |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,319,760.00             | 600,000.00                 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 1,684,446.00             | 794,352.00                 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 330,000.00               | 286,000.00                 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 43,350,970.00            | 65,258,996.74              |
| 210807 | Газрын төлбөр  | 1,968,000.00             | 1,858,818.00               |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | 38,400.00                | 152,600.00                 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                               | 1,664,272.56             | 0.00                       |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>7,864,746,260.34</b>  | <b>8,051,672,064.01</b>    |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 63,723,117.00            | 20,951,646.00              |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх                                     | 41,501,625.00            | 18,872,354.00              |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал                            | 7,759,521,518.34         | 8,011,848,064.01           |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>134,944,257.80</b>    | <b>401,532,501.81</b>      |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>134,944,257.80</b>    | <b>401,532,501.81</b>      |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 800,000.00               | 0.00                       |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 11,388,737.00            | 1.81                       |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 122,755,520.80           | 401,532,500.00             |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>25,424,133,362.83</b> | <b>(11,230,220,401.49)</b> |
| 225    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | <b>40,848,579.56</b>     | <b>5,528,631.67</b>        |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал  | 40,848,579.56            | 5,528,631.67               |
| 4      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | <b>(40,848,579.56)</b>   | <b>(5,528,631.67)</b>      |
| 5      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>25,383,284,783.27</b> | <b>-11,235,749,033.16</b>  |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны дүн            | Тайлант жилийн дүн       |
|------------|--|--------------------------|--------------------------|
| <b>1</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>18,786,510,580.95</b> | <b>31,157,710,232.30</b> |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>1,209,684,200.95</b>  | <b>999,670,690.39</b>    |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 1,209,684,200.95         | 999,670,690.39           |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 1,209,684,200.95         | 999,670,690.39           |
| 1200041    | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 874,241,773.89           | 775,739,970.00           |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 335,442,427.06           | 210,345,240.39           |
| 1200044    | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих  | 0.00                     | 13,585,480.00            |
| <b>13</b>  | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>17,576,826,380.00</b> | <b>30,158,039,541.91</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 0.00                     | 974,347,903.71           |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00                     | 974,347,903.71           |
| 1340       | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>  | 17,576,826,380.00        | 29,183,691,638.20        |
| 134002     | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих  | 17,576,826,380.00        | 29,183,691,638.20        |
| <b>2</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>26,382,788,828.62</b> | <b>28,565,301,761.33</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>26,382,788,828.62</b> | <b>28,565,301,761.33</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 26,195,878,428.62        | 28,056,237,191.44        |
| 2101       | <b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 14,034,221,514.67        | 15,900,916,307.34        |
| 210101     | Үндсэн цалин   | 6,782,118,500.44         | 6,516,298,414.74         |
| 210102     | Нэмэгдэл   | 4,987,088,881.79         | 7,642,583,182.99         |
| 210103     | Унаа хоолны Хөнгөлөлт  | 1,181,997,081.75         | 1,021,371,454.76         |
| 210104     | Урамшуулал   | 873,975,330.33           | 716,315,020.29           |
| 210105     | Гэрээт ажлын хөлс  | 209,041,720.36           | 4,348,234.56             |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 1,546,470,005.35         | 2,711,850,990.00         |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 1,073,386,805.35         | 2,069,701,000.00         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 121,310,300.00           | 288,684,390.00           |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 96,882,000.00            | 58,911,100.00            |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 23,913,800.00            | 58,911,100.00            |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 230,977,100.00           | 235,643,400.00           |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 1,002,540,788.38         | 976,852,798.29           |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 470,374,131.19           | 543,403,601.93           |
| 210302     | Түлш, халаалт  | 166,554,232.27           | 146,965,213.30           |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 365,612,424.92           | 286,483,983.06           |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 744,135,750.67           | 697,839,414.68           |
| 210401     | Бичиг хэрэг  | 194,973,313.00           | 123,100,925.00           |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 68,264,700.00            | 35,056,263.00            |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 29,951,990.81            | 22,703,786.68            |
| 210404     | Ном, хэвлэл  | 12,884,750.00            | 0.00                     |

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

|          |  |                           |                           |
|----------|--|---------------------------|---------------------------|
| 210405   | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                  | 110,227,700.00            | 147,996,400.00            |
| 210406   | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                | 327,833,296.86            | 368,982,040.00            |
| 2105     | <b>Нормативт зардал</b>  | 7,814,146,962.65          | 6,704,260,591.75          |
| 210501   | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 6,048,426,743.00          | 5,611,862,287.00          |
| 210502   | Хоол, хүнс   | 1,572,691,219.65          | 916,762,304.75            |
| 210503   | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 193,029,000.00            | 175,636,000.00            |
| 2106     | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                   | 563,201,586.00            | 530,763,832.00            |
| 210601   | Багаж, техник, хэрэгсэл  | 214,019,510.00            | 168,026,900.00            |
| 210602   | Тавилга  | 83,555,600.00             | 3,500,000.00              |
| 210603   | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 38,968,000.00             | 39,056,200.00             |
| 210604   | Урсгал засвар  | 226,658,476.00            | 320,180,732.00            |
| 2107     | <b>Томилолт, зочны зардал</b>  | 20,538,896.00             | 37,750,000.00             |
| 210702   | Дотоод албан томилолт  | 20,538,896.00             | 37,750,000.00             |
| 2108     | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>            | 354,542,727.90            | 366,739,222.74            |
| 210801   | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж       | 288,933,251.90            | 283,204,356.00            |
| 210802   | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                   | 12,000,000.00             | 0.00                      |
| 210803   | Даатгалын үйлчилгээ  | 1,319,760.00              | 600,000.00                |
| 210804   | Тээврийн хэрэгслийн татвар   | 1,684,446.00              | 749,352.00                |
| 210805   | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 330,000.00                | 327,000.00                |
| 210806   | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 48,268,870.00             | 79,999,696.74             |
| 210807   | Газрын төлбөр  | 1,968,000.00              | 1,858,818.00              |
| 210808   | Банк санхүүгийн үйлчилгээний хураамж                                       | 38,400.00                 | 0.00                      |
| 2109     | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | 116,080,197.00            | 129,264,034.64            |
| 210901   | Бараа үйлчилгээний бусад зардал  | 80,345,220.00             | 103,842,082.64            |
| 210902   | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 35,734,977.00             | 25,421,952.00             |
| 213      | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 186,910,400.00            | 509,064,569.89            |
| 2132     | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 146,927,200.00            | 453,238,941.89            |
| 213204   | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                             | 200,000.00                | 0.00                      |
| 213207   | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                        | 11,388,737.00             | 77,516,441.89             |
| 213209   | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                    | 135,338,463.00            | 375,722,500.00            |
| 2133     | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                         | 39,983,200.00             | 55,825,628.00             |
| 213303   | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 39,983,200.00             | 55,825,628.00             |
